



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/699

Арвайхээр

Г Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.a, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр суманд баригдаж буй 50 ортой хүүхдийн эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Хангамж–Өргөө" ХХК-ийн гүйцэтгэж буй ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй буулгалт, хүзүүвч, холбооны шугам сүлжээ, лифт, гадна фасадны зөрүү ажлыг нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.
2. Нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д даалгасугай.
3. Нэмэлт ажилд шаардагдах 639.057.571 (зургаан зуун гучин есөн сая тавин долоон мянга таван зуун далан нэг) төгрөгийг Сангийн яаманд уламжлан тендерийн үнийн зөрүү зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101329

D:My Doc. Zahiramj. Zasag darga